

ХЭЛ, СОЁЛЫН ШҮТЭЛЦЭЭ

М. Булганцэцэг, магистр, МУБИС

Abstract: This article looks at the relationship between language and culture. Firstly, the author mentioned about the Sapir-Whorf hypothesis which describes the relationship between language, culture and thought. The linguist Edward Sapir and his student Benjamin Lee claimed that the structure of a language influences how its speakers view the world. Secondly, the real life examples taken from Arabic and Eskimo languages in this article show that people's perceptions of their surroundings are modified by the conceptual categories their languages happen to provide. Data such as the following are sometimes cited in support of such claims. A well-known example is that Eskimos have countless words for snow while there is only one word 'snow' in English. Therefore, a 'snow world' in an Eskimo's eye and an English speaker's eye would be so different. Bedouin Arabic has many words for different kinds of camels, and just as the Inuits have many words for different kinds of snow. At third, we looked at how culture and life style are reflected in the proverbs and realia of a nation. In conclusion, the author recommends translating realia using the appropriate translation methods.

Түлхүүр үг: үгийн сангийн түвшин, хэлний бүтэц, ертөнцийг үзэх үзэл, сэтгэлгээний онцлог, зүйр цэцэн үг, үндэсний онцлог үг

Удиртгал

Энэхүү өгүүллэгийн эхний хэсэгт хэл, соёлын талаар талаар эрдэмтдийн дэвшүүлсэн тодорхойлолт болон Америкийн нэрт хэл судлаач Э.Сапир, Б.Л.Уорф нарын хэл шинжлэлийн харьцангуй онолын талаар дурьдав.

Өгүүллэгийн үндсэн хэсэгт хэл, соёлын хоорондын холбоо, шүтэлцээний талаар эрдэмтдийн дэвшүүлсэн онолыг Араб болон Эскимо хэлний аж хэрэглээний жишээ, баримттай холбож тайлбарлахыг зорилоо.

Хэл соёлын шүтэлцээ нь хэлний бүх түвшнээс үгийн сангийн түвшинд илүү их илэрдэг. Хэл-соёлын уялдаа, шүтэлцээний тухай асуудал нийт хүн төрөлхтний анхаарлыг татсаар байна. Эрдэмтэд хэл, соёлыг дараах байдлаар олон талаас нь тодорхойлж иржээ.

Хэл нь тухайн улсын соёлыг үеэс үед дамжуулдаг хэрэглүүр юм. Аль ч улсын соёл, ахуй амьдрал, ёс заншил, хэл яриа нь өвөрмөц

онцлогтой. Үндэстний хэл бүр тухайн үндэстний соёлын дүр төрхийг харуулдаг. Хэл үндэстний соёл бүрэлдэн тогтох, хөгжихөд шууд нөлөөлөх чадамжтай (Равдан, 2005).

Хэл, соёл нь хүн төрөлхтөн, эсвэл аль нэг тодорхой үндэстэн ястны ертөнцийг үзэх үзэл, ертөнцийг таньсан байдал, түүнд хандах хандамж буюу байгаль, нийгмийн юм үзэгдэл, үйл байдал, хэрэг явдал, шинж чанар тэргүүтнийг тодорхойлохын зэрэгцээ тэрхүү онцлог нь уг үндэстний сэтгэлгээний тогтвортой хэв шинж болж, улмаар төрөлх хэлнийх нь ямар баримт хэрэглэгдэхүүнд тусч илэрсэн болохыг судалдаг (Баянсан, 2010).

Хэлний бүтэц, тогтолцоо нь аливаа хэлээр ярилцагчдын бодол санаа, ертөнцийг үзэх үзлийг илэрхийлдэг (Anderson & Lightfoot, 2002; Crystal, 1987; Hayes, Ornstein, & Gage, 1987).

Хэл, соёлын шүтэлцээний асуудлыг анх XX зууны эхэнд Америкийн нэрт судлаач Э.Сапир, Б.Л.Уорф нар хэл шинжлэлийн харьцангуй онолынхоо хүрээнд анх боловсруулжээ. Тэд “Аливаа үндэстний соёл, зан заншил нь тэдний өдөр тутмын хэл ярианд илүү их тусгагддаг нь тухайн ард түмний түүх, үнэт зүйлс, аж хэрэглээ зэрэг олон хүчин зүйлтэй холбоотой” гэж тодорхойлжээ.

Америкийн хэлшинжээч Фишман Э.Сапир, Б.Л.Уорф нарын харьцангуй онолын талаар “Аливаа нэг хэлэнд юмс, үзэгдлийг хэд хэдэн янзаар нэрлэдэг бол тэрхүү юмс, үзэгдлийг нэрлэх, тодорхойлох үг нөгөө хэлний үгийн санд байхгүй байж болно. Хэл бүрт байхгүй утгын нарийн ялгамжийг илэрхийлсэн үгс нөгөө хэлэнд байгаа нь тухайн хэлээр ярилцагчдын аж хэрэглээтэй холбоотой” гэж тодорхойлжээ.

Зарим хэлэнд аливаа ухагдахууныг нэг л үгээр илэрхийлдэг байхад нөгөө хэлэнд тэр ухагдахууныг илэрхийлсэн хэд хэдэн тусгай үг байх жишээтэй (Crystal, 1987).

Хэл, соёлын хоорондын холбоо, шүтэлцээний талаар эрдэмтдийн дэвшүүлсэн онолыг бусад хэлний жишээ баримттай холбож үзье.

Бедуйнчууд хойд Африкаас дундад Ази хүртэл үргэлжлэх өргөн уудам говь цөлийн бүсэд тэмээ, ямаа хариулан амьдарч ирсэн хагас нүүдэлчин амьдралтай улсууд юм. Бид газар сайгүй морины уралдаан зохион байгуулдаг бол Арабууд ганц бөхт тэмээ уралдуулан нааддаг аж. Ингэхдээ

тэмээг нас, хүйсээр нь уралдуулна. Бедуйнчууд цаг үетэйгээ хөл нийлүүлж, гар утас, интернет ашигладаг болсон ч тэдний амьдралд тэмээ чухал үүрэгтэй байсаар иржээ. Үүний нэг жишээ нь тэд машинтай болсон ч тэмээгээ зарна гэсэн ойлголт байхгүй. Лалынхны “Коран” сударт хүртэл тэмээний тухай 19 удаа дурьдсан байдаг гэнэ. Тэмээ нь аз жаргал сайн сайхныг авчирдаг гэдэгт тэд итгэдэг.

Тэмээний нас, эрхтэн, тэдгээрийн хэлбэр дүрс, хэмжээ зэргийг харгалзан нэрлэсэн хэдэн арван үг Арабууд тэр дундаа Бедуйнчуудын үгийн санд бий. Манай говийнхны нэгэн адил тэд тэмээндээ нэр өгөхдөө тэмээний зүс, хурд зэрэг онцлог шинжийг нь харгалздаг аж. Бедуйнчууд тэмээний эрхтэн тус бүрийг дараах байдлаар тусгайлан нэрлэдэг байна.

1	sanaam - hump (бөх)
2	sulb - back (нуруу)
3	ghaarib - shoulders (мөр)
4	khuff - soles of the feet (тэмээний тавхай)
5	farsam - the foot (хөл)
6	'arnuun - the bridge of the nose (хамрын үзүүр)

8	khashm - nose (хамар)
9	burtam - snout (хошуу)
10	hijaaj - forehead (дух)
11	Manhar - lower part of the neck (хүзүүний доод хэсэг)
12	dar' - udder (дэлэн)
13	shabiib - tip of the tail (сүүлний үзүүр)

Араб хэлэнд тэмээтэй холбоотой 60 орчим үгс байдаг нь тэдний аж хэрэглээ, ахуй соёлыг тодорхой хэмжээгээр харуулж байна. Араб хэлэнд морь болон тэмээг төрөл зүйлээр нь ялгах тусгай үгс олон бий. Харин Англи хэлэнд тэдгээрийн нарийн ялгамжийг илэрхийлсэн тусгай үгс байхгүй. Тиймээс *quarter horse, dray horse* гэх мэтээр нэр үгийн хэлхэц үүсгэж хэрэглэдэг. Бусад хэлэнд ийм жишээ олныг дурдаж болно. Тухайлбал, Бразилийн Банива овгийнхон шоргоолжийг нэрлэсэн - 29 үг, Орос болон Скандинавын хойд хэсгээр амьдардаг Самичууд цаа бугатай холбоотой 1000 үг, хойд туйлд амьдардаг эскимосчууд цастай холбоотой 53 үг, Америкийн Нэгдсэн Улсын Хавайн арлынхан гадил жимсийг нэрлэсэн 47 орчим үг, загасны торыг нэрлэсэн - 65, чихрийн нишэнгийг нэрлэсэн - 42 үгийг тус тус хэрэглэдэг аж.

Хойд туйлд нутаглаж амьдарч ирсэн, амьдралын өвөрмөц хэв маягтай Эскимосчууд

цасыг маш олон янзаар нэрлэдэг. Тухайлбал:

	Эскимо	Англи	Монгол
1	aqilokoq	softly falling snow	зөөлөн унаж буй цас
2	piegnartoq	good for driving sled	чарга хөллөхөд тохиромжтой цас
3	wa-ter	melted snow	хайлсан цас
4	trayling	snow melted with mud	шавартай холилдож хайлсан цас
5	slimtla	snow that is crusted on top but soft underneath	дээд талдаа хатуурч дагдаршсан, харин доороо зөөлөн байгаа цас
6	kriplyana	snow that looks blue in the early morning	өглөө эрт цэнхэртэн харагдах цас
7	jatla	snow between your fingers or toes	хөлийн хуруунуудын хоорондох цас

Дээрх жишээнээс харахад бидний “цас” гэж нэрлэдэг тэрхүү ухагдахууныг эскимосчууд янз бүрээр нэрлэдэг нь тухайн үндэстний эрт дээр үеэс нутаглан аж төрж ирсэн нутаг, газарзүйн тогтоц байршил, түүний байгаль цаг уурын нөхцөл байдал, амьдралын хэв маяг, байгалийн элдэв үзэгдлийн шинж төлөв, онцгой хүчин зүйлийн нөлөөнөөс үүдэлтэй байна. Энэ бүх хүчин зүйл үндэстний сэтгэлгээний өвөрмөц онцлог бүрэлдэн тогтох эх сурвалж болж байна.

Хэл-соёлын холбоо хамаарлыг ардын үлгэр домог, ерөөл магтаал, туульс, ардын дуу шүлэг зэрэг билэг сургаалын зүйлсээс авхуулаад зүйр цэцэн үг, өвөрмөц, хэвшмэл хэллэг, оньсого таавар зэрэг хэлний тогтвортой илэрхийллүүд юуны түрүүнд судалгааны хэрэглэгдэхүүн болно. Учир нь тухайн төрөлх соёл-хэлтний ертөнцийг үзэх үзэл, ертөнцийг таньсан байдал, эртнээс нааш эдүгээ хүртэл бүтээн туурвиж, ашиглаж хэрэглэн, улмаар өвлөн уламжилж ирсэн эдийн болон оюуны соёлын зүйлсийн тухай ухаарал, мэдлэг ухаан нь чухам эдгээр илэрхийлэлд тод томруун хадгалагддаг учиртай (Баясан, 2010).

Англи болон Монгол хүмүүсийн сэтгэлгээний онцлог, хэл соёлын ялгаа, орчин зэрэг нь хоёр хэлний зүйр цэцэн үгэнд хэрхэн тусгагдсаныг дараах жишээнээс харья.

Төрөөгүй хүүхдэд төмөр өлгий

Үүнтэй төстэй боловч утгын хувьд бага зэрэг ялгаатай “Don't count your chickens before they

are hatched” гэсэн зүйр цэцэн үг англи хэлэнд байна. “Төрөөгүй хүүхдэд төмөр өлгий” гэдэг нь аливаа зүйлд хэт эртлэн хөдлөх хэрэггүй гэсэн монгол ухаан юм. Энэ нь болох аливаа эрсдлээс сэргийлэх сэтгэлгээний онцлогийг илтгэдэг. Харин барууныхны хувьд тэдний хандлага энэ тал дээр арай өөр. Нэн эртнээс бүх зүйлээ зэхэж, урьдчилан тооцоолсноор айдсаа даван туулсан итгэл төгс байдлыг илэрхийлдэг аж. Бидний сэтгэл зүйн ялгаатай байдлын нэг энэ яах аргагүй мөн.

Буруу хүмүүжүүлсэн хүүхэд бухын хүзүүнээс хатуу

Буруу хүмүүжсэн гэдэг нь хүмүүжилгүй эрхээрээ хатсан гэсэн үг. Англиар *spoiled, spoil* гэж хэлдэг. Хэрэв энэ зүйр үгийг үгчилж орчуулбал англичууд ойлгохгүйгээр барахгүй гайхна. *Бухын хүзүү* гэдгийг сонсоод англи хүнд тийм ч сайн төсөөлөл буухгүй. Энэ тохиолдолд утгыг нь хадгалж өөр үгээр буюу бэлэн байгаа зүйр цэцэн үгээр орчуулах нь зүйтэй. Үүнтэй утга дүйх “*To spare the rod and spoil the child*” гэсэн англи хэлц бий. Англичууд хүүхдээ шийтгэхдээ саваа модоор ороолгодог учир “*Саваагаа гамнаж, хүүхдээ эрхлүүлэх*” гэж хэлдэг байна.

Ялихгүй юмнаас ямааны гарз

“*Жижиг зүйлийн төлөө том зүйлийг битгий золиосло*” гэсэн утгатай энэхүү хэлцийн англи хувилбар нь “*Burn not your house to rid it of the mouse*” гэсэн үг байдаг ба англи хэлэнд зүйр үг ихэвчлэн сүүл холбосон байдаг. Энэ жишээнд “*house*”, “*mouse*” гэсэн төсөөтэй дуудлагатай үгээр цохилт үүсгэж байна. Харин Монгол хэлэнд ихэвчлэн толгой холбодог ба энэхүү зүйр үгийг “*Я*” гэсэн үсгээр толгой холбожээ.

Even reckoning makes long friends

“Тооцоогоо тэгш хуваах нь нөхөрлөлийг бэхжүүлдэг” гэсэн утгатай зүйр үг. Монгол логикоор мөнгөө нарийн тооцох нь нөхөрлөлийг сулруулж, найз нөхдөө өөрөөсөө холдуулж ч болох бол англи сэтгэлгээр харин ч улам бэхжүүлдэг ажээ. Зарим хүмүүс нарийн тооцоотой хүнийг *харамч амьтан* гэж ад шоо үздэг бол англичууд *сайн нөхөр* хэмээн үнэлдэг байх нь. Эндээс мөн адил англичуудын сэтгэлгээний онцлог харагдаж байна.

Цаашид зүйр үгсийг орчуулахад хоёр талын сэтгэлгээний онцлог, соёл, уламжлалыг харгалзахын зэрэгцээ зүйр үгийн уран яруу байдлыг хадгалж, үг нэг бүрчлэн эсвэл тухайн зүйр цэцэн үгэнд байгаа үгийг багтаах гэхээсээ илүү утгаасаа огтхон ч гажиж болохгүй. Зүйр цэцэн үгийг орчуулахад тухайн хоёр хэлний хэл, соёлын ялгаа, амьдарч буй орчин, ахуй соёл, аж

хэрэглээ зэргийг харгалзах нь зүйтэй.

Аль ч улсад тухайн орны соёл, сэтгэлгээний онцлогийг тусгасан үгс элбэг байдаг. Үндэсний онцлог үг нь зөвхөн тухайн хэлний хүрээнд бүрэн утгаараа хэрэглэгддэг боловч гадаад хэлэнд галиглах, үгчлэх, тайлбарлах, ойролцоо утгатай үгээр орчуулах зэрэг аргаар орчуулагддаг.

“The UB Post” сонины 2015 оны 2 сарын 16-ны № 019-ны дугаарт “Tsagaan Sar Traditions” (Орчуулсан Ч. Халиун) нийтлэлд дараах үндэсний онцлог үгийг үгчлэх аргаар орчуулсан нь үгийн сангийн утгыг алдагдуулжээ.

1	the right door-post	гэрийн баруун тотго
2	the left door-post	зүүн тотго
3	prayer scarf	хадаг
4	White month-	Цагаан сар
5	Traditional fermented vodka	архи
6	Traditional biscuits	хэвийн боов

Энэ орчуулгаас харахад гадныханд манай үндэсний баярын талаар ямар нэг өөр ойлголт, сэтгэгдэл төрж болзошгүй юм. Хуулбарлан орчуулах нь тухайн хэлний үгсийн санд шинэ соргог үг, хэллэг нэвтрүүлэх таатай боломж бий болгож байгаа хэдий ч гадаад үг, нийлэмж үг бүрийг ингэж хуулбарлаад байвал үгчилсэн “модон орчуулга” болох сөрөг нөлөөтэй. (Ү. Цэцэгням, 2015)

Үндэсний онцлог үг хэллэг нь тухайн үндэстнийх өөрийнх нь учир өөр хэлэнд хэл, соёлын ялгаанаас үүдэн шууд дүйх үг байхгүй боловч зөв тохирсон утгаар орчуулах нь хэлээр дамжуулан тухайн ард түмний ахуй соёл, аж хэрэглээг таниулах чухал үүрэгтэй.

ДҮГНЭЛТ

Хэл-соёлын шүтэлцээ нь хэл ба нийгмийн харилцан хамаарлын хүрээнд багтаж буй асуудал юм. Судлаачдын тодорхойлсноор хэл соёл нь дараах шүтэлцээтэй.

- Аж хэрэглээний үүднээс хэл, соёлын харьцаанд хөтлөгч хүчин зүйл нь соёл болно. Соёл хэлэнд нөлөөлж, хэлийг тодорхойлдог.
- Хэл, соёл нь хүн хийгээд хүний хүчин зүйлгүйгээр үл оршино. Тийм учраас хүний хүчин зүйлийн асуудал нийт хэл шинжээч, гадаад хэл заах аргачдын анхаарлын төвд орших учиртай.
- Хэл нь соёлыг түгээгч, дамжуулагч гол гүүр, гол хэрэглүүр юм.
- Хэл, соёлын шүтэлцээний тухай асуудал нь

орчин үеийн гадаад хэл заах аргын хүрээнд хэл шинжлэлийн нэгэн хавсарга судлал болон өргөжжээ.

Энэ бүгдээс үзэхэд соёл нь ард түмний түүхэн цаг хугацаанд хэвшиж дадсан амьдралын хэв маяг юм. Харин хэл, соёлын шүтэлцээг тухайн улс үндэстний, ард түмний түүхэн цаг хугацааны явцад хэвшин тогтсон амьдралын хэв маяг загварчлагдан хэлэндээ шингэж, хэл өөрөө эргээд энэхүү ёс заншил, амьдралын хэв маяг, сэтгэлгээний онцлогийг илэрхийлэх хэрэгсэл болдог.

Хэл, соёлын холбоо хамаарлыг тодорхойлдог хэлний тогтвортой илэрхийллийн нэг нь зүйр цэцэн үг бөгөөд энэ нь өвөрмөц хэлцийн бие даасан нэг хэлбэр юм. Зүйр цэцэн үгийг орчуулахад үндэстний сэтгэлгээний онцлог, соёл, уламжлалыг харгалзан орчуулах нь чухал гэдэг санааг дэвшүүлэв.

Үндэсний онцлог үг нь тухайн орны соёл, сэтгэлгээний онцлогийг тусгадаг тул үгчлэн орчуулах нь үгийн утгыг алдагдуулж, гадаад хүнд өөр ойлголт, сэтгэгдэл төрүүлэх сөрөг талтай тул орчуулгын зөв тохиромжтой аргаар орчуулах шаардлагатай байна.

АШИГЛАСАН МАТЕРИАЛ

- Аким, Г. (2001). *Монгол зүйр цэцэн үгийн товч тайлбар толь*. Улаанбаатар
- Болормаа, Б., Булганцэцэг, М. (2013). *Ерөнхий хэл шинжлэл*. Улаанбаатар: Экимто
- Гүрбазар, Р. (1996). *Орчуулгын онол, дадлагын үндэс*. Улаанбаатар
- Дорждагва, Т. (2011). *Соёл судлал*. Монголын соёл судлалын холбоо. Улаанбаатар
- Соёл урлагийн их сургууль. *Соёл судлалын их семинар*. (2008). Улаанбаатар
- Төмөртогоо, Д. (2004). *Хэлшинжлэлийн толь бичиг*. Улаанбаатар, “Адмон” ХХК
- Цэцэгням, Ү. (2015). Үндэсний онцлог үгийн орчуулга. НХУС-ийн ЭШБ №1. Улаанбаатар: Ган Уран Бичээс
- Janice Raymond. (2010). *Mongolian Proverbs: A Window into Their World*. U.S.A